

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН СУМДАД ХОЛБОГДОХ ЗААЛТУУД

Цагаандэлгэр сум

2018.12.03

Шийдвэр №	Заалт №	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилт /гаргах чиглэл/	Үнэлгээ
УИХ-ын тогтоол					
1	1	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016-11-03 Дугаар 2016 №51	2.. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2017-2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд нийт 27 ажил арга хэмжээ төлөвлөсөн ба 2018 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 83,3%-тай байна.	100
УИХ-ын байнгын хорооны тогтоол					
2	2	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016-03-26 Дугаар 2016_09/03	1.5/. Бүх шатны Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулах асуудлыг Засаг даргын үр дүнгийн гэрээнд тусгаж, үүрэгжүүлж ажиллуулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо -1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байгаа. Байнгын асаргаанд байх шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин гэмтэлийн жагсаалтаас уруул тагнайн сэтэрхий гэх онош нь хасагдан тул асаргаанд орох боломжгүй болсон.	100
Ерөнхийлөгчийн зарлиг					
3	3	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа,	“Вектор мэл” ХХК нь орон нутгийн хөгжлийн сангийн 4.274,400 төгрөгний хөрөнгөөр сумын төвийн хаягжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Цаашид албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахаар төлөвлөгөөтэй ажиллаж байна.	70

			аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.		
ЗГ-ын тогтоол					
4	4	Журам батлах тухай 2016-03-14 Дугаар 2016_153	2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын дагуу "Сум хөгжүүлэх сан"-гийн журмын хэрэгжилт үйл ажиллагаанд Хяналтын зөвлөлийн дарга Г.Дэмбэрэлжав, нарийн бичгийн дарга Ж.Чулуунтогтох нарын хамт 1 удаа шалгалт хийж зээл, зээлийн хүү төлөх талаар хугацаатай албан мэдэгдэл хүн тус бүрт хүргэн гарын үсэг зуруулан хүлээлгэн өгч ажиллалаа. Мөн сар тутам зээлдэгч нартай 2-оос доошгүй удаа утсаар ярьж анхааруулан ажиллаж байна. Хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд 13 иргэн, 2 ААН-ийн үндсэн зээл 26.016.725 төгрөг, зээлийн хүү 2.603.341 төгрөг бүгд 28.620.066 төгрөгийг "Сум хөгжүүлэх сан"-д төвлөрүүлэн ажилласан. Одоогоор СХС-д 15 иргэний зээл хэрэгжиж байгаагаас гадна 5 иргэн зээл, зээлийн хүүгээ бүрэн төлөн хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна. 2018 оны 12 сарын 1-ны байдлаар Сум хөгжүүлэх санд 43.518.758 төгрөг төвлөрсөн байна. Сум хөгжүүлэх сангаас программ шинэчлэн суулгасны төлбөрт 750.000 төгрөг, шуудан холбоонд 120.000 төгрөг, бичиг хэргийн зардалд 90.000 төгрөг буюу 960.000 төгрөгийн зардал гарч дансны үлдэгдэл 133.112.520 төгрөг байна. 2017 онд Ауйдтын байгууллагаас сум хөгжүүлэх сангийн өр авлага 75134256 төгрөгийн акт тавигдснаас хугацаа хэтрэлттэй өр авлага 52314341 төгрөгийн өр барагдуулан ажиллаж, үлдэгдэл 22819915 төгрөгийн хэтрэлт байгаагаас шүүхэд 2 иргэний 11634250 төгрөгийн өрийг барагдуулахаар явуулсан байна. Одоо зээлийн хэтрэлт 11185665 төгрөгийн өртэй байна. Өр барагдуулалт 85,1 хувь байна.	100

5	5	“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батлах тухай 2018-01-10 Дугаар 2018_12	3.. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, явц, үр дүнг жил бүрийн 5 дугаар сард багтаан Засгийн газарт тайлагнаж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Хэрэгжүүлээгүй.	0
6	6	Аргачлал шинэчлэн батлах тухай “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал” 2018-01-24 Дугаар 2018_20	2. Аргачлал батлагдсантай холбогдуулан хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээллийг дараа оны 2 дугаар сард багтаан “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д оруулан баталгаажуулж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Аргачлал батлагдсантай холбогдуулан хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээллийг 2 дугаар сард багтаан “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д оруулан баталгаажуулсан	100
7	7	2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай 2018-01-31 Дугаар 2018_32	2.1. “Хариуцлагын жил”-ийн хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулж тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан дүгнэж ажиллах;	2018 оныг МУ-ын ЗГ-аас хариуцлагын жил болгон зарласантай холбогдуулан суманд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 2018.04.11-ний өдөр сумын Засаг даргаар 12 бүлгийн 36 ажил төлөвлөж жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг тооцож хэрэгжилт 90%-тай байна.	100
	8		2.2. яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэлбэрэлтгүй	Сумын хэмжээнд 2018 оны байдлаар 335 өргөдөл ирснээс 331 өргөдлийг хуулийн хугацаанд нь шуурхай шийдвэрлэсэн бөгөөд судлагдах шатандаа байгаа 4 өргөдөл байна. Үүнээс: Засаг дарга, түүний тамгын газарт хандан 2018 оны байдлаар 257	100

		биелүүлж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авах;	өргөдөл ирснээс өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд судлагдах шатандаа байгаа 4 өргөдөл байна. Ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд 13 санал, өргөдөл, гомдол, Соёлын төвийн хүрээнд 4 санал, өргөдөл, гомдол, Хүүхдийн цэцэрлэгийн хүрээнд 35 санал, өргөдөл, гомдол, Эрүүл мэндийн төвийн хүрээнд 22 санал, өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	
9		2.3. төрийн захиргааны бүх шатны байгууллага ажиллагсадтайгаа байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллаж байх;	ЗДТГ нийт албан хаагчидтай үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас жилээр дүгнэхэд төрийн захиргааны 6 албан хаагчаас А үнэлгээтэй 1, В үнэлгээтэй 3, дүгнүүлээгүй 2 албан хаагч, төрийн үйлчилгээний 6 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг дүгнэхэд А үнэлгээтэй 3, В үнэлгээтэй 1, С үнэлгээтэй 1, D үнэлгээтэй 1 албан хаагч байлаа. С болон D үнэлгээтэй дүгнэгдсэн 2 албан хаагчид цаашид ажил сайжруулах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. ЭМТөв хөдөлмөрийн гэрээг нийт ажилчидтай байгуулж улирал тутам дүгнэж, үр дүнгийн урамшуулал олгодог. Эхний 3 улирлын үр дүнг тооцон урамшуулал олгосон. Хариуцлага тооцогдсон ажилтан байхгүй. Сар бүр ажилчдаас тайлан авдаг. Соёлын төв албан хаагчдын ажлын үр бүтээлийг улирал бүр бодитой дүгнэж, 3 албан хаагчид 3 удаа ур чадварын нэмэгдэл олгосон. Соёлын төвийн 3 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээг байгуулан хагас жилээр ажлын үзүүлэлтийг дүгнэсэн. Бүх ажилчдын голчийг харахад гүйцэтгэлийн хувь 89%-тай гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлэн ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар ажилчдын цалинг цаг тухайд нь олгож, 3 албан хаагчид тус бүр 1, 2, 3-р улиралын ур чадварын нэмэгдэл, сургалт семинарт хамрагдсан 2 албан хаагчийн томилолтыг олгож, ээлжийн амралтыг хуваарийн дагуу биеэр эдлүүлж, 3 албан хаагчид цалингийн урьдчилгаа, 3 албан хаагчид банкны зээл зэргийг тус бүр олгосон байна.	100
10		2.4. 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга	Суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах	100

8			хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан төсөл, арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрэгжүүлж ажиллах;	үнэлгээний хороо байгуулагдаагүй. Услын төсвийн 250 сая төгрөгийн хөрөнгөөр нийтийн халуун ус, ахуй үйлчилгээний барилга барих ажлын гүйцэтгэгчээр “Одда тайж” ХХК шалгаран ажлаа гүйцэтгэж байна. Тендер аймагт зарлагдаж үнэлгээний хороо аймагт байгуулагдсан.	
	11		2.5. “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах.	ЗГ-ын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1 дүгээр албан даалгаврын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2017.11.03-ны өдөр сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг тооцон ажиллалаа. Төлөвлөгөөнд нийт 16 заалт бүхий ажил арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 96,2%-тай байна.	100
	12		4.. “Хариуцлагын жил”-ийн хүрээнд иргэн бүр хууль тогтоомжийг судлан мөрдөж, хувь иргэний эрх, үүргийг нийтийн эрх ашиг, үндэсний язгуур ашиг сонирхолтой зөв хослуулах замаар байгаль орчноо хайрлан хамгаалах болон эрхэлсэн ажил, оршин суугаа баг, хорооныхоо хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод хувь нэмэр оруулж ажиллахыг уриалсугай.	2018 оныг МУ-ын ЗГ-аас хариуцлагын жил болгон зарласантай холбогдуулан суманд 2018 оны оныг бүтээн байгуулалтын жил болгон зарласан. Энэ ажлын хүрээнд иргэдийн дунд уралдаан зарлаж бүтээн байгуулалт хийсэн айл өрхийг шалгаруулж урамшуулахаар төлөвлөж шалгаруулалтыг 12 сарын 10-нд зохион явуулна. Багийн Засаг дарган нар иргэдэд шинэчлэн гарсан хууль тогтоомж, мэдээ мэдээллийг цаг тухай бүрт хүргэж аливаа үйл ажиллагаанд малчип иргэдийг татан оролцуулж байна. Тухайлбал 1 иргэний ашгаас бусад хүний эрх ашиг хөндөгдөхөөс сэргийлж гэр хорооллын дунд нарийн гудамж гаргаж, нохой эзэмших журмыг айл өрхүүдэд нэг бүрчлэн тарааж эрх үүргийг сурталчлан таниулж аливаа эрсдлээс өөрийгөө болоод бусдыг хамгаалах ач холбогдлыг ойлгуулах гэх мэт ажлууд хийгдэж байна.	100
8	13	Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2018-05-23 Дугаар 2018_138	2.. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга	Засгийн газрын 2018.04.04-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, 2018 оны 138-р тогтоолыг үндэслэн төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах, төрийн байгууллагуудад интернетийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор ажлын байранд ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд /facebook, youtube, twitter/ нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай ЗДТГ-ын	100

			хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй.	албан хаагчид, байгууллагын дарга нарт хуралдааны тэмдэглэл болон 138-р тогтоолыг танилцуулан гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилласан.	
9	14	Хөдөө аж ахуйн салбарын 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2018-07-04 Дугаар 2018_218	3. . Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай. 3.1. Хөдөө аж ахуйн салбарын 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтэд нь хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь шуурхай авч ажиллах; 3.2. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг заасан хэмжээнд бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах; 3.3. Бэлчээрийн даацад тулгуурлан сум дундын болон аймаг дундын отрын бүс нутгууд, хилийн зурвас газар, байгалийн тусгай хамгаалалттай газруудад отроор өвөлжүүлэх асуудлыг өрх, малын тоог тохирон холбогдох газруудтай гэрээ байгуулан зохион байгуулах; 3.4. Хадлангийн талбайг нэмэгдүүлэх, хаших, хамгаалах, тэжээлийн ургамал тариалах, усжуулах ажлыг аймаг, орон нутгийн малчдын бүлэг, хоршоо, аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулан зохион байгуулах; 3.5. Зарим	3.1 Сумын Засаг даргын 2018 оны 08-р сарын 02-ний А/65 тоот захирамжаар мал аж ахуйн болон төв суурингийн 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийг байгуулж, 16 заалт бүхий сумын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж өвөлжилтийн бэлтгэл 81,3%-тай хэрэгжиж байна. Мөн төв суурин болон хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах сумын Засаг даргын албан даалгавар гарган малчдад өгсөн. 3.2 Сумын өвс , тэжээлийн аюулгүйн нөөцөд 8.3 тн өвс, 11.8 тн тэжээлийн нөөцийг бүрдүүлээд байна. 2018.10.15-нд Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхжаргал 2018-2019 оны өвөл, хаварт аймгаас аймаг дундын отрын бүс нутагт отроор өвөлжих малын тоог батлан аймгуудтай гэрээ хийсэн байна. Хэнтий аймгийн Хэрлэнбаян Улааны аймаг дундын отрын бүс нутагт 25000, Говь-Сүмбэр аймгийн Малхын талын аймаг дундын отрын бүс нутагт 35000 малыг тус тус отроор оруулахаар гэрээ байгуулах ажлын хэсэгт сумын Засаг дарга Д.Буджав орж ажилласан. Өнөөдрийн байдлаар манай сумаас гадны аймаг суманд отроор гарсан малчин өрх байхгүй бөгөөд өөрийн нутгийн бэлчээрийн даацдаа тохируулан сум дотроо өвөлжих хандлагатай байна. Цаг хүндэрсэн нөхцөлд тус сумаас 30000 мал оторлуулах төлөвлөгөөтэй байна. 3.4 Хадлангийн талбайг хашиж, хамгаалсан эсэх, тоо баримт	70

		шаардлагатай хадлангийн талбайг өнжөөх, сэлгэх, өөр аймгийн нутагт хадлан бэлтгэх гэрээ, хэлэлцээр хийж зохицуулах; 3.6. Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчний эсрэг дархлаажуулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах, мал эмнэлгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж, шуурхай удирдлагаар хангаж ажиллах; 3.7. Агаарын хуурайшилт их байгаатай холбогдуулан зун, намрын отор хийх газар, нутгуудад улсын болон орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгөөр шинээр худаг гаргах ажлыг шуурхай зохион байгуулах; 3.8. Бэлчээрийн хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажилд улсын төсвийн хөрөнгөөс гадна орон нутгийн төсөв, сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс зарцуулах, малчдын өөрсдийн санаачлагыг дэмжин, удирдан зохион байгуулах, гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сайжруулах; 3.9. Малын хашаа, саравч, худаг, уст цэгээ засварлах, тохижуулах, түлш бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсний нөөц бүрдүүлэх зэргээр малчин өрхийн өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангуулах, ажлыг зохион байгуулах; 3.10. Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлтгэл, зохион байгуулалтыг хангуулан цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацаа хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллах; 3.11. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангуулах, нөөц бүрдүүлэх зорилгоор шаардлагатай эм,	3.5 Малчид өвс 167.2 тн, тэжээл 100.1 тн, гар тэжээл 64 тн-ыг бэлтгэсэн байна. 3.6 Малын гоц халдварт Шүлхий өвчин гарсны улмаас 4650 үхэрт давтан тарилтаар 2 удаа, 362 тэмээ, эрүүл бүсийн 11288 хонь, 8810 ямаа нийт 25110 малын урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан байна. Шөвөг яраас сэргийлэх вакциныг 79 өрхийн 7078 хурга, 11344 ишиг нийт 18422 төлд хийгээд байна. Цусан халдвартын вакцинд 3960 бог, дотрын халдварт хордлогын вакцинд 4104 бог мал, бруцеллёзын вакцинд тугал 187, хурга, ишиг 7856 төл хамруулсан байна. Туулгалтанд хонь 8750, ямаа 3636, мал угаалгад нийт 13580 малыг хамруулсан. 3.7 Улсын төсвийн хөрөнгөөр 4-р багийн малчин Ц.Живаагийн гүн өрмийн худаг гаргаад байна. Америкын хөрөнгө оруулалттай Манна хөгжил ТББ-ийн 15 сая төгрөгийн хөрөнгөөр хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн хашаанд гүн өрмийн худаг гаргасан. 2018 оныг бүтээн байгуулалтын жил болгож иргэд, албан байгууллагуудын дунд уралдаан зарлаж 1-р багийн иргэн П.Бурмаа хувийн хэрэгцээнд 6 сая төгрөгөөр гүн өрмийн худаг гаргасан. 3.8 Бэлчээрийн үлийн цагаан оготнотой тэмцэх ажилд малчдыг оролцуулж микробиологийн аргаар 2.2 тн бактержуулсан будааг малчдын өвөлжөө, хаваржааны орчимд цацлаа. Мөн утах төхөөрөмжөөр 4 мотоциколь, 10 хүн 10 хоногийн хугацаанд утаж үр дүнгээ өгч байна. 3-р улиралд мөн 17000 га талбайд 10 сая төгрөгөөр бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой тэмцэх ажил зохион байгуулсан. 3.9 Малчдад малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлш бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсний нөөц бүрдүүлэх зэргээр хувийн бэлтгэлийг сайтар хангах талаар сумын Засаг даргын албан даалгаврыг 165 малчин өрхөд өгсөн.	
--	--	--	--	--

			эмнэлгийн хэрэгсэл, түргэн тусламжийн машины засвар үйлчилгээг хийж, бүрэн бүтэн байдлыг хангах; 3.12. Орон нутагтаа болон отроор өвөлжиж (хаваржиж) байгаа малчдын судалгаанд үндэслэн эрүүл мэндийн явуулын үйлчилгээ үзүүлэх хуваарь гаргах, ялангуяа амаржих дөхсөн болон эрсдэлтэй жирэмсэн эхийг аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын тогтмол хяналтад байлгах, бага насны хүүхдийг дархлаажуулах явуулын баг ажиллуулах; 3.13. Малчид, орон нутгийн удирдлага болон мах, гурил, тэжээлийн үйлдвэрийн 3 талт гэрээ байгуулж, мал, мах борлуулах, хүнс, малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах; 3.14. Нийт нутгаар хуурайшилт ихтэй байх цаг уурын урьдчилсан мэдээг үндэслэн хадлангийн талбайг орон нутгийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, говийн аймгуудад гэрээ, түрээсээр ашиглуулах ажлыг зохион байгуулах.	3.10 2018 онд 20 өрх төмс 80 кг, сонгино 18 кг, хүрэн манжин 0,3 кг, шар манжин 0,3 кг, шар лууван 0,2 кг, өргөст хэмх 280 ш, чинжүү 0,5 кг–ыг тарьсан байна. Намар ургац хураалтаар сумын хэмжээнд 15 өрх төмс, хүнсний ногоо хураан авч ажилласнаас төмс 600кг, лууван 100 кг, хүрэн манжин 30 кг, улаан лооль 40 кг, чинжүү 40 кг, сонгино 90 кг, өргөст хэмх 550 кг, шийгуа 30 кг-ыг хураан авсан дүн мэдээтэй байна. Уг мэдээ мэдээллийг аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар мэдээлсэн байна. 3.11 Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн УАЗ-469 машин бүрэн бүтэн байдлыг хангаж шаардлагатай засвар үйлчилгээг хийж эмнэлгийн дуудлага үйлчилгээнд явж байна. Эмийн хэрэгслийн нөөц 70-80% орчим байна. 3.12 Отроор болон нутагтаа байгаа эрсдэлтэй жирэмсэн эмэгтэй байхгүй. 2017 оны эцсээр 4 эх хяналтанд байснаас 2018 онд 18 эх хяналтанд орж 11 эх амаржсан. Жирэмсний хяналтанд 11 эх байгаагаас 4 эх хоёр дахь шатлалтын эмнэлэгт шилжиж одоо 7 хяналтанд байна. Жирэмсэн эхчүүдийг 338-р тоот тушаалын дагуу товлот үзлэгийг 6-8 удаа үзэж 36-38 долоо хоногтойд төрөх газар төлөвлөж солилцох хуудсын хамт илгээж байна. 0-1 сар хүртлэх нярайг их эмч эх баригчийн хамт 7 хоног бүр, эх нярайн эргэлтийг хийж үнэлж дүгнэж байна. 0-5 насны 110 хүүхдийг эмнэлгийн хяналтанд авч 4 багийн эмч болон их эмч нар байнгын үзлэг хяналтыг тавьж, товлолын дагуу вакцинаа хамрагдаж байна.	
10	15	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай: 1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн	ЗДТГ-аас бүх ажилтан, албан хаагчидтай ёс зүй, хариуцлагын гэрээг байгуулсан. Соёлын төв албан хаагчдын сахилга хариуцлагын гэрээг шинэчилж мөрдөн ажиллаж байна. ЕБС-иас багш, ажилчидтайгаа хөдөлмөрийн гэрээ, ёс зүйн гэрээг нэг бүрчлэн байгуулж, багшлах эрхийн үнэмлэхтэй багш нарыг ажлын байраар ханган ажиллуулж байна. төсвийн байгууллагууд албан хаагчидтай хагас жилээр ёс зүйн гэрээг дүгнэсэн. Ёс зүйн зөрчил гаргасан 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.	100

		албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх;	Хариуцлагын жил болгон зарласан ЗГ-ын 32-р тогтоол, ЗГ-ын 2017 оны 01 тоот албан даалгавар, 2018 оны 258-р тогтоолыг ЗДТГ-ын албан хаагч, байгууллагын дарга нарт тухай бүр нь танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсан. Үүний дагуу харъяа төсвийн байгууллагууд албан хаагчиддаа сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж ажиллах талаар гарсан тогтоод шийдвэрийг танилцуулж мөн гарын үсэг зурж баталгаажуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах талаар чиглэл өгсөн. Ажлын хариуцлага алдсан 5 албан хаагчид сануулах болон цалингийн хувиар арга хэмжээ тооцсон бол ёс зүйн зөрчил гаргасан 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.	
16		1.2. иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх;	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандаж ирүүлсэн санал, өргөдөл, гомдлын бүртгэн авч холбогдох ажилтанд өгч шийдвэрлүүлэн хуулийн хугацаанд хариуг өгч ажиллаж хэвшсэн. Төрийн байгууллага, багийн Засаг дарга нар, албан хаагчдад ирүүлсэн СӨГХ-ийг улирал тутам ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтан нэгтгэн аймгийн ЗДТГ-т мэдээлдэг. Засаг даргын Тамгын газрын СӨГомдол хүлээн авах утас 89643553, ЭМТ-д 89826055 нээлттэй утаснуудыг ажиллуулж байна. Албан байгууллага, албан хаагч нарт 2018 онд иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдол, ирсэнийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд хяналтын картаар хяналт тавьж, улирал бүрийн эцэст СӨГ-ийн мэдээг нэгтгэн тайланг холбогдох байгууллагад цахимаар болон цаасаар хугацаанд нь хүргүүлж ажилласан. 2018 оны 11 сарын эцсийн байдлаар нийт 335 санал хүсэлт, өргөдөл гомдлоос 331 СӨГ-ийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, иргэдэд хариуг цаасаар болон утсаар, биеэр уулзаж хариуг өгч ажиллалаа.	100
17		1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн	ЗДТГ-ын даргын 2017.11.02-ны өдрийн А/34 тоот тушаалаар ажлын байрны тодорхойлолт дахин боловсруулах ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилон нийт албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтуудыг Төрийн албаны зөвлөлийн 2004 оны	100

		давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	34-р тогтооллоор баталсан аргачлалын дагуу боловсруулж архив албан хэрэг хөтлөлт, ажлын хариуцлага, тайлан мэдээ өгөх зэрэг зорилтуудыг нэмж тусгасан. Албан хаагчдын үр дүнгийн гэрээн болон хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргүүд ажлын байрны үндсэн болон гол зорилтуудтай нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсэн. Тухайлбал ЭМТ 18 ажилчдын ажлын байрны тодорхойлолтонд анализ, дүгнэлт хийж шинэчилсэн. Орлон гүйцэтгэх ажлыг илүү сайн тусгаж оруулсан. Соёлын төвөөс ажлын байрны тодорхойлолтыг ажлын хэсэг гарган шинэчлэн боловсруулж, албан хаагчдын ажил үүрэг, ажлын ачаалал зэргийг тэнцвэржүүлэн баталгаажуулсан байна.	
18		1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;	ЗДТГ-т төрийн сангийн мэргэжилтний сул орон тоо гарч төрийн албаны шалгалт өгч тэнцэн нөөцөд бүртгэлтэй байсан Ж.Чулуунтогтох томилуулах саналыг ТАСЗ-д хүргүүлж томилох санал дүгнэлт ирснээр томилсон. Уг мэргэжилтэн нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт өгснөөр 7 сард ажлаасаа чөлөөлөгдөж дахин сул орон тоо гарсан. Иймд ЗДТГ-ын улсын бүртгэгч Д.Бат-Оршиход төрийн сангийн мэргэжилтний ажлыг түр хавсруулан гүйцэтгүүлж байна. ЗДТГ-т төрийн жинхэнэ албан тушаалын 3 /Байгаль орчны байцаагч, төрийн сангийн мэргэжилтэн, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн/ орон тоо гарч тус бүрт нь аймгийн ТАСЗ-д ажлын байрны захиалгыг хүргүүлсэн.	100
19		1.5. төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох;	Төрийн захиргааны удирдах албан тушаалд томилгооны зөрчил байхгүй. ЭМТ-ийн даргын сул орон тоо гарч захиалгыг аймгийн ТАСЗ-д хүргүүлснээр сонгон шалгаруулалт 12 сарын 18-нд явагдахаар зарлагдсан байна.	100

20	1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;	Төрийн жинхэнэ албан хаагчийн 3 сул орон тооны захиалгыг аймгийн ТАСЗ-д хүргүүлсэн. Төрийн сангийн мэргэжилтний ажлын байрыг улсын бүртгэгчид түр хавсруулан хариуцуулж, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтний орон тоонд тусгай дунд боловсролтой иргэн ажиллаж байгаа томилгооны зөрчлийг арилгах зорилгоор Ц.Ундрахбаярыг ХААИС-д эчнээгээр суралцуулан 12 сард төгсөхөөр ажиллаж байна.	70
21	1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;	12. ЗДТГ-ын албан хаагч болон байгууллагын дарга нарт ЗГ-ын 258-р тогтоолыг танилцуулж байгууллагынхаа ажилтан, албан хаагчдад танилцуулах талаар үүрэг чиглэл өгч ажилласнаар бүх төрийн албан хаагчид сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 258-р тогтоолтой танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсан. Төсвийн байгууллагууд уг тогтоолд тусгасны дагуу 9-р сард дотоод журамдаа албан томилолтын явцад болон ажлын болон ажлын бус цагаар ажлын байрандаа согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглох тухай заалтыг нэмж оруулсан. Зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	100
22	1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;	2018 онд сахилгын шийтгэлтэй 6 албан хаагч байна. Сахилгын шийтгэлийг ажлын хариуцлага алдаж, ёс зүйн зөрчил гаргасны улмаас хариуцлага тооцуулсан. 258-р тогтоол хэрэгжсэнээр албан хаагчдын ажлын хариуцлага сайжирч ямар нэг ёс зүйн зөрчил дутагдал гараагүй. Төрийн байгууллагуудын удирдлагууд болон ажилтан албан хаагчидтай ёс зүй, хариуцлагын гэрээ байгуулж дүгнэн мөрдөж ажиллаж тухай бүр үүрэг чиглэлийг тогтмол өгч ажилласан.	70
23	1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын	Сумын төрийн байгууллагаас ЗДТГ, ЭМТ хурууны хээгээр цаг бүртгэж давхар цаасан бүртгэл хөтөлдөг. Төрийн албан	100

		хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;	хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулж, хариуцлагажуулах шаардлагыг бусад байгууллагуудад тавьснаар соёлын төв, ЕБС, цэцэрлэг хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмж суурилуулан сумын бүх төрийн байгууллага ажлын цагийг хурууны хээгээр бүртгэж байна. Ажилчдын цаг ашиглалтын бүртгэлд дотоод хяналтын баг тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Цэцэрлэг, ЭМТ, ЗДТГ-ын дотоод камер тогтмол ажиллаж байна.	
24		1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;	Төрийн байгууллагуудын удирдлага болон бусад албан хаагчдын зүгээс ажлын байран дахь дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийн талаар ямар нэг санал гомдол ирээгүй байна. Уг тогтоолд тусгасны дагуу 1.7, 1.10 дахь заалтуудыг 2018.09.10-ны өдөр албан хаагчдаараа хэлэлцүүлж дотоод журамдаа өөрчлөлт оруулж 6-р бүлгийн 6.1.2/й/, 6.5.1/с/ дэхь заалтуудыг нэмж тусган баталгаажуулсан. Төсвийн байгууллагуудаас соёлын төв дотоод журмын 9.4, ЭМТ 8.1-8.4, ЕБС 4.3-4.5, цэцэрлэг 10.9, 10.12 дахь заалтуудыг нэмж тусгаж мөрдөж ажиллалаа.	100
25		3.. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга , Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг 8 сард АЗДТГ-аас ирж зохион байгуулсан. Үүнтэй холбогдуулан 10 сард ЗДТГ-ын дотоод хяналтын нэгжээс харъяа төсвийн байгууллагуудад гэнэтийн шалгалт хийж заавар зөвлөгөө өгч ажилласан.	70

11	26		6.. Аймаг, сумын хүнс, хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн газар, тасгийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангахыг Хүнс, хөдөө ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.	Мал аж ахуйн онцлог, ажлын ачааллыг харгалзан сумын мал эмнэлэг, үржлийн нэгжийг хөдөө аж ахуйн тасаг болгон өөрчилж, мал эмнэлгийн тасгийг шинээр байгуулж орон тооны хязгаарыг баталж өгсөн. Шинээр тасаг нээгдэхтэй холбогдуулан өрөө тасалгаа, техник хэрэгслийг бэлтгэж байна.	100
	27	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-08-22 Дугаар 2018_267	7.. Аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн газар, сум, дүүргийн тасгийн орон тоо, цалингийн сан, үйл ажиллагааны зардлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн багцад зохицуулалт хийж, санхүүжүүлэх арга хэмжээ авах, цаашид жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	Суманд мал эмнэлгийн тасаг байгуулагдсантай холбогдуулан сумын ЗДТГ-ын орон тооны хязгаарыг тогтоож өгсөн. Тасгийн орон тоо, цалингийн сан, үйл ажиллагааны зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн багцад зохицуулан шийдвэрлэсэн.	100
Ерөнхий сайдын захирамж					
12	28	Гамшиг, галын аюулгүй байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-04-06 Дугаар 2018_68	1.5. Зориулалтын бус барилга байгууламжид иргэд, олон нийтийг хамруулсан үйл ажиллагаа зохион байгуулснаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй хэрэг зөрчил гарч байгаа явдлыг илрүүлэх, таслан зогсоох, гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын шаардлагыг хангуулахтай холбоотой үйл ажиллагаанд өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, уялдаа, зохион байгуулалтаар хангахыг Монгол Улсын Шадар сайд, бүх шатны Засаг дарга нарт.	Тус сумын соёлын төвийн барилга нь 1954 онд баригдаж одоог хүртэл тус барилгад үйл ажиллагаа явуулж байна. барилгын чанар, бүтээц нь муудаж гадна талын хананы шавар хөндийрч нурах аюултай болсон учир уг барилгын ойр орчимд бага насны хүүхэд тоглуулахгүй байх, аваарын тууз татсан хэсэгт нэвтрэхгүй байх тухай мэдэгдлийг байгууллагын дарга эрхлэгч, багийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын шаардлагыг хангуулахтай холбоотой үйл ажиллагаанд өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүй мэргэжил, арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор сумын ГХУСАСЗ-ийн 2018 оны 7 сарын 5-ны өдрийн хурлаар осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр айл өрх албан байгууллагат үзлэг шалгалт хийж хяналт тавьж зөвлөгөө өгөх ажлын хэсгийг 4 хүний	100

				бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. 2018 оны 7 сарын 5, 16-ны өдрүүдэд сумын төвийн айл өрх албан байгууллагаар явж хяналт шалгалтийн ажлыг зохион байгуулж үзлэгт 50 өрх, 14 аж ахуйн нэгж хамрагдлаа. Хяналт шалгалтын явцад кабель утас ил байгаа, кабелийн утас солих, ашиглагдаагүй кабелийн уасыг цэгцлэх зэрэг зөрчлүүд илэрсэн. Зөрчилтэй айл өрх 15, 6 аж ахуй нэгжид зөрчил арилгах хугацаатай мэдэгдэл болон эзэмшлийн зааг, эзэмшигч, хангагчийн эрх үүргийг танилцуулж гарын үсэг зуруулж баталгаажуулан зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа.	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					
13	29	2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр 16 дугаар тэмдэглэл 2018-04-04 Дугаар 2018_16	ХҮ.2. Ажлын байранд, ажлын цагаар интернэт ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн захирлуудад үүрэг болгосугай.	Засгийн газрын 2018.04.04-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, 2018 оны 138-р тогтоолыг үндэслэн төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулах, төрийн байгууллагуудад интернетийн зохистой хэрэглээг бий болгох зорилгоор ажлын байранд ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд /facebook, youtube, twitter/ нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох тухай ЗДТГ-ын албан хаагчид, байгууллагын дарга нарт хуралдааны тэмдэглэл болон 138-р тогтоолыг танилцуулан гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилласан ба байгууллагууд дотоод журамдаа энэ талаарх өөрчлөлтийг тусган мөрдөж ажиллалаа.	100
14	30	2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2018-05-16 Дугаар 2018_21	ХХIX.2. 3. . Бодлогын баримт бичгийн зорилт, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барилыг оновчтой ашиглан бодитой, хэрэгцээт мэдээллээр удирдлага, дээд шатны байгууллагыг хангахад анхаарч ажиллахыг	1. Сумын эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний саналыг 2018.12.05-ны өдөр Засаг даргын албан тоотоор сумын ИТХ-д өргөн мэдүүлсэн. 2. Сумын эдийн засаг, нийгмийн 2018 оны үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг сумын ИТХ-аар хэлэлцүүлэхээр сумын Засаг даргын албан тоотоор хүргүүлсэн.	100

			сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	3. 2017 оны сумын үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтийг сумын ИТХ-ын 2017.12.19-ний өдрийн хуралдаанд танилцуулж хэлэлцүүлсэн.	
	31		XXIX.2. 4. Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр Албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэн, зөрчил дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр хариуцлага тооцон ажиллахыг төрийн байгууллагын удирдлагуудад даалгав.	ЗГ-ын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1 дүгээр албан даалгаврын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2017.11.03-ны өдөр сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг тооцон ажиллалаа. Төлөвлөгөөнд нийт 16 заалт бүхий ажил арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 96,2%-тай байна.	100
15	32	2018 оны 8 дугаар сарын 29-ний өдөр 36 дугаар тэмдэглэл 2018-08-29 Дугаар 2018_36	XIV.1. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон албан тушаалтанд хандаж иргэдээс 2018 оны эхний хагас жилд “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	2018 онд иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг хүлээн авч, удирдлагад танилцуулж, нийт 335 санал, өргөдөл, гомдлыг 2018 оны 12-р сарын 05-ны өдөр Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Улирал бүрийн эцэст төрийн байгууллага, багийн Засаг дарга, мэргэжилтнүүдээс ирсэн СӨГ-ийн мэдээг нэгтгэн ЗДТГазрын даргаар хянуулан тайланг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т цахимаар болон цаасаар хугацаанд нь хүргүүлж ажилласан. 2018 онд нийт 335 санал хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, иргэдэд хариуг цаасаар болон биеэр уулзаж харилцан ажилласан.	100
ЗГ-ын албан даалгавар					
16	33	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	1.. Шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, төрийн бүх шатны байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас дараах албан даалгаврыг өгч	1. Байгууллагын дотоод журам, ёс зүйн гэрээг зөрчиж ажлын цагаар архи ууж согтуурсан 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.	100

		2017-10-26 Дугаар 2017_01	байна: 1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад: 1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах;	2. Сумын Засаг дарга Д.Буджав, 3-р багийн Засаг дарга Г.Дэмбэрэлжав нар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр ажилладаг. 4-р багийн Засаг дарга Д.Мягмардорж аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байна. 3. 2018 оны эхэнд сумын 5 байгууллагын удирдлагууд албан хаагчидтайгаа ёс зүй, хариуцлагын гэрээ байгуулсан. Сумын Засаг дарга байгууллагын дарга, эрхлэгч нартай 2018.02.14-нд ёс зүй, хариуцлагын гэрээ байгуулсан.	
	34		2.. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 2.1. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах;	1. Энэ онд Засаг даргын орлогч, 1, 2-р багийн Засаг дарга нийт 3 улс төрийн албан хаагч шинээр томилогдсон. АТГ-ын дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэст материалыг хүргүүлэн ашиг сонирхлын зөрчилгүй тухай албан тоот ирсний дараа томилсон. 2. 2019 оны 1 сарын 1-ээс хэрэгжих Төрийн албаны тухай хуулийн сургалтанд 78 төрийн албан хаагч, ЗГ-ын 2018 оны 32, 258-р тогтоолыг танилцуулах сургалтанд 26, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаарх сургалтыг төрийн албан хаагчдад хийж нийт давхардсан тоогоор 131 иргэн, төрийн албан хаагчийг хамруулсан.	100
	35		1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх;	Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой санал гомдол гараагүй. Төрийн албан хаагчдад захиргааны шийдвэр гаргах, аливаа асуудал хэлэлцэж шийдвэрлэхийн өмнө ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл тайлбарыг гаргаж ажиллах талаар мэдээлэл хийсэн. 5 мэдэгдэл тайлбар гарсасныг цаасаар бүртгэж авч дээд шатны байгууллагын даргын зөвшөөрлийг тухай бүрт нь өгч ажилласан.	100

36	1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах;	1. 7059106-д төрийн албан хаагчийн талаар 1 гомдол ирүүлснийг холбогдох хэлтэст хариуг өгч ажилласан. Өөрөөр суманд сахилга хариуцлагатай холбоотой өргөдөл ирээгүй байна. 2. Ажлын хариуцлага алдсан 5 албан хаагчид сануулах болон цалингийн хувиар арга хэмжээ тооцсон бол ёс зүйн зөрчил гаргасан 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.	100
37	1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих;	Цаг бүртгэлийн систем 5 байгууллагад нэвтрүүлэн ашиглаж ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулахад анхаарч ажиллалаа. Цаг бүртгэлийн төхөөрөмжгүй байсан 3 байгууллагад шаардлага тавьж хурууны хээгээр цаг бүртгэх төхөөрөмжийг суурилуулан цалин бодоход ашиглаж байна. мөн цаасан бүртгэлийг давхар хөтөлж байна.	100
38	1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх.	Дутагдалтай боловсон хүчний судалгааг гаргасан. Сургуульд дуу хөгжмийн багш, соёлын төвд хөгжмийн багш, ЭМТ-д сувилагч 1, ЗДТГ-т 3 орон тоо дутагдалтай байна. 2018 онд цэцэрлэг СӨБ-ийн багш, тогооч, ЕБС-д 3 багш, ЭМТ-д 1 их эмч дутагдалтай байсныг нөхөж байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Үүнээс ЭМТ-ийн 2 сувилагч, соёлын төвд 1 ажилтан, ЗДТГ-аас жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн зэрэг хүмүүсийг мэргэшүүлэх сургалт болон эчнээ ангиудад суралцуулсан байна. Төрийн албыг тасралтгүй явуулах зарчмыг баримтлан байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллахад сургалт семинарт тогтмол хамруулж мэргэших, мэргэжил эзэмшихэд нь байгууллагын зүгээс дэмжин суралцах хугацааны цалинтай чөлөө олгож дэмжиж ажиллаж байна. Тухайлбал цэцэрлэгийн тулах багшийг СӨБ-ийн сургуульд сургаж, ЭМТ-ийн үйлчлэгч Д.Янжинлхамыг сувилахуйн сургуульд, 2 багшийг магистрын сургалтанд, соёлын төвийн номын санч Д.Мөнхтуяаг СУИС-ын соёлын боловсролын сургуульд номын санч, мэдээллийн ажилтнаар суралцуулж төгсгөсөн байна. Мөн төрийн албан	100

				хаагчдыг салбарын болон бусад шагнал урамшуулалд тодорхойлж 1 багш боловсролын тэргүүний ажилтан, 1 эмч ЭМЯ-ны жуух бичиг, 1 ажилтан БСШУСЯ-ны жуух бичиг, 1 албан хаагч МХЕГ-ын өргөмжлөл, 1 багш Залуучуудын холбооны “Тэргүүний залуу” алтан медаль, 1 багш аймгийн Засаг даргын жуух бичгээр тус тус шагнагдсан. Мөн нийгмийг баталгааг хангах ажлын хүрээнд ахуйн дэмжлэг туслалцааг хууль журмын дагуу үзүүлж ажилласан.	
	39		2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах;	Сумын 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, газар олголттой холбоотой асуудлыг цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод, нээлттэй мэдээлж байна.	70
	40		2.3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх;	Сумын ЗДТГ-аас 4 сарын 18-нд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж ЗДТГ-ын албан хаагчид мэдээлэл хийж, иргэдийн асуултанд тухай бүр холбогдох албан хаагчид хариулт өгч ажилласан. Мөн 4 багийн нэгдсэн өдөрлөгийг 6-р сард зохион байгуулж иргэдтэй уулзалт зохион байгуулсан. Мөн 9-р сард багуудын иргэдийн нийтийн хуралд ЗДТГ-ын дарга, мэргэжилтнүүд баг тус бүрийн хуралд оролцож цаг үеийн ажлаар мэдээлэл хийж иргэдийн асуултанд хариулж ажилласан. 2019.01.01-ээс мөрдөгдөж эхлэх төрийн албаны хууль болон төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх зохилгоор Цагаандэлгэр сумын төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг 2018.10.29-ны өдөр зохион байгуулж нийт 8 байгууллагын 68 албан хаагч 9 ахмад төрийн албан хаагч нар оролцсон. Зөвлөгөөн хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулагдсан.	100
	41		2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр	Ажлаа цалгардуулсны улмаас хариуцлага тооцуулсан 1 албан хаагчид төрийн албаны тухай хууль, 258-р тогтоолын дагуу	100

			нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх;	хариуцлага тооцсо. Мөн ажлын хариуцлага алдсан 4 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.	
	42		2.5. Удирдлага, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах.	ЗДТГ нийт албан хаагчидтай үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас жилээр дүгнэхэд төрийн захиргааны 6 албан хаагчаас А үнэлгээтэй 1, В үнэлгээтэй 3, дүгнүүлээгүй 2 албан хаагч, төрийн үйлчилгээний 6 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээг дүгнэхэд А үнэлгээтэй 3, В үнэлгээтэй 1, С үнэлгээтэй 1, D үнэлгээтэй 1 албан хаагч байлаа. С болон D үнэлгээтэй дүгнэгдсэн 2 албан хаагчид цаашид ажил сайжруулах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. ЭМТөв хөдөлмөрийн гэрээг нийт ажилчидтай байгуулж улирал тутам дүгнэж, үр дүнгийн урамшуулал олгодог. Эхний 3 улирлын үр дүнг тооцон урамшуулал олгосон. Соёлын төвийн 3 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээг байгуулан хагас жилээр ажлын үзүүлэлтийг дүгнэсэн. Бүх ажилчдын голчийг харахад гүйцэтгэлийн хувь 89%-тай гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлэн ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар ажилчдын цалинг цаг тухайд нь олгож, 3 албан хаагчид тус бүр 1, 2, 3-р улиралын ур чадварын нэмэгдлийг тус бүр олгосон байна.	100
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал					
17	43	Ажлын хэсэг байгуулах тухай /Аймаг, сум, дүүрэгт хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан, авлига, хээл хахуулийн хэрэгт холбогдсон, хүнд суртал гаргасан, ажлын байран дээр	2.. 1.1 Зорилго: Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилт, зохион байгуулсан ажил, арга хэмжээний явц, үр дүн, Ерөнхий сайд, Шадар сайд нараас ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах чиглэлээр төрийн бүх шатны байгууллагад өгсөн үүрэг, чиглэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан	Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг 8 сард АЗДТГ-аас ирж зохион байгуулсан. Үүнтэй холбогдуулан 10 сард ЗДТГ-ын дотоод хяналтын нэгжээс харъяа төсвийн байгууллагуудад гэнэтийн шалгалт хийж заавар зөвлөгөө өгч ажилласан. Мөн ЗГХЭГ, ТАЗ-ын хамтарсан тушаалаар баталсан удирдамжийн дагуу төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх судалгааны ажлын хэсэг тус суманд 11 сарын 24-нд ирж ажиллан 8 төрийн жинхэнэ албан төстийн болон мэдээлэл технологийн шалгалтанд хамрагдаж хуулийн шалгалтын дундаж оноо 75%, мэдээлэл технологийн дундаж оноо 67%-тай үнэлэгдсэн байна.	100

		архидан согтуурсан, хадгалсан албан тушаалтантай 2018-08-31 Дугаар 2018_255 эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгах, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулахад оршино. 1.2 Шалгалт явуулах үндэслэл: Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг удирдлага болгоно. Хоёр. Шалгалтын хамрах хүрээ, хугацаа, шалгах чиглэл 2.1 Хамрах хүрээ: Аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд хамрагдана. 2.3.1 Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол бусад холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаж байгаа байдал;	Нийт 12 албан хаагчтай ярилцага хийж, бичиг баримтыг үзэж цаашид анхаарах асуудлууд дээр заавар, зөвлөгөө өгсөн. ЗГ-ын 2018 оны 258-р тогтоолыг хэрэгжүүлэх 20 заалт бүхий төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг жилийн эцсээр тооцож ажиллахад 94%-тай хэрэгжиж байна.	
44		2.3.3 . байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ;	ЗДТГ нь албан хаагчдынхаа ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах ажлын хэсгийг тушаалаар батлан ажиллуулж ажил үүргийн хуваарь, ачааллыг тэнцвэржүүлэх талаар саналаа хэлэлцэн ажлыг байрны тодорхойлолтод тусган шинэчлэн баталсан. Цэцэрлэгээс ажлын байрны тодорхойлолтонд дүн шинжилгээ хийж дахин боловсруулах ажлын хэсгийг эрхлэгчийн 16 тоот тушаалаар томилон ажиллуулаа. Ажлын хэсэг нь албан хаагчдад хуучин ажлын байрны тодорхойлолтыг 7 хоног судлах чиглэл өгч, багш ажилчидад ажлын байрны тодорхойлолт гэж юу вэ, хэрхэн хэрэгжүүлж, ажиллах талаар сургалтыг 09 сарын 19-нд зохион байгуулан 11 ажилтан оролцлоо. 09 дүгээр сарын 20-ны өдөр ажлын байрны тодорхойлолтын талаар хэлэлцүүлэг, дүгнэлт гаргаж харилцан ярилцаж шинээр оруулах саналуудыг тусган ажлын байрны тодорхойлолтыг шинээр зааврын дагуу	100

			боловсруулан, ажилтан нэг бүрт танилцуулан гарын үсэг зуруулж, ажлын хэсгийн ахлагч гарын үсэг зурж, эрхлэгчээр баталгаажууллаа. ЭМТ нь 2018 онд 18 ажилчдын ажлын байрны тодорхойлолтонд анализ, дүгнэлт хийж шинэчилсэн. Орлон гүйцэтгэх ажлыг илүү сайн тусгаж оруулсан. Албан хаагчдын хувийн хэргийн шинэчлэн бүрдүүлж ажиллаж байна. Соёлын төвөөс 2018 оны 01 сары 24-ны өдөр ЗГ-ын 34 дугаар тогтоолын дагуу Соёлын төвийн 4 албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж ажил үүргийн чиг үүргийг нарийвчлан тогтоож, ажлын ачааллыг тэнцвэржүүлсэн. Томилогдсон ажлын хэсэг нь Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль зэргийг бусад албан хаагчдад танилцуулж ажиллалаа. ЕБС-аас ажлын байрны тодорхойлолтонд дүн шинжилгээ хийж ажлын давхардал хийдлийг тэнцвэржүүлэхэд анхаарч захиралын тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилж 22 албан хаагчийн тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж албан хаагчдад танилцуулж баталгаажуулсан.	
45	2.3.4. төрийн жинхэнэ албан хаагчдыг томилохдоо хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, үйл ажиллагааны үр дүнг харгалзсан эсэх, хуулиар хүлээсэн үүрэг, ажлын байр /албан тушаал/-ны шалгуур шаардлагыг хангалтгүй биелүүлсэн албан хаагчдад хариуцлага оногдуулсан байдал;	Төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэж 6 төрийн жинхэнэ албан хаагчаас А үнэлгээтэй 1, В үнэлгээтэй 3 албан хаагч байлаа. 2 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн учир гэрээгээ дүгнүүлээгүй. Ажлын байр /албан тушаал/-ны шалгуур шаардлагыг хангалтгүй биелүүлсэн албан хаагч байгаагүй.	100	
46	2.3.5 . төрийн албан хаагчдтай холбоотой гэмт хэрэг, зөрчил, сахилга ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцлийг тогтоон, сахилга, ёс зүйн зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр	Төрийн албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулсан байдлаас харахад ажлын хариуцлага, ёс зүйн зөрчилтэй холбоотой байна. Иймд төрийн албан хаагчдыг ажлаа чанартай хийж гүйцэтгэх, ажилдаа хариуцлагатай байхыг тухай бүр сануулж, ажлын өдөр ажлын цагаар архи согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан	70	

		үр дүнд хүрэхүйц ажил зохион байгуулсан байдал;	зогсоох арга хэмжээ авч байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, сахилга ёс зүйн гэрээг байгуулж ажилласан.	
	47	2.3.6 . ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, байгууллагын дотоод дүрэм, журамд тусган мөрдүүлж ажилласан байдал;	Төрийн байгууллагуудын удирдлага болон бусад албан хаагчдын зүгээс ажлын байран дахь дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийн талаар ямар нэг санал гомдол ирээгүй байна. Тогтоолын 1.10 дахь заалтыг байгууллагууд дотоод журамдаа тусган ажиллаж байна.	100
	48	2.3.8 . байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах, харуул хамгаалалт, сонор сэрэмжийг дээшлүүлэх, гарч болзошгүй аливаа эрсдлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан байдал;	Байгууллагуудын дотоод аюулгүй байдлыг хангаж төрийн байгууллагууд гадна гэрэлтүүлэг хийсэн. Сургууль, цэцэрлэг, ЭМТ-д байнгын жижүүр ажиллаж байна. ЗДТГ, ЭМТ, цэцэрлэг хяналтын камер ажиллуулж байна. Цаашид төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд болон сумын төвийг камержуулах ажлыг шийдвэрлэхээр зорилт тавин ажиллаж байна.	70
	49	2.3.9 . согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон албан хаагчид хариуцлага тооцсон эсэх, сахилгын шийтгэлийг ажлаас халах хүртэл хүндрүүлэн оногдуулсан байдал;	Архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хариуцлага тооцуулсан албан хаагч байхгүй. Сумын Засаг даргын захирамжийн дагуу сар бүрийн 5, 15, 25-ний өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх талаар албан мэдэгдэл хүргүүлж Сайнгашуун, Сирина дэлгүүрийн ажиллах цагийн хуваарьт хяналт тавьж ажилласан. Мөн 21 насанд хүрээгүй, согтуу хүнд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх, хүлээлгэх хариуцлагын талаар санамж, сэрэмжлүүлэг тараасан. Архидалтгүй аймаг Дундговь хөтөлбөрийн хүрээнд аймгийн АА бүлгээс ирж архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, архины зохистой хэрэглээ, гэр бүл, хамт олонд архидалтгүй орчинг бий болгоход чиглэгдсэн сургалтыг төрийн албан хаагчдад зохион байгуулсан. Мөн хөтөлбөрийн хүрээнд 10 сарын 7-нд Говь-угтаал суманд болсон сургалтанд байгууллагын дарга эрхлэгч нар хамрагдсан.	100
	50	2.3.10 . нутаг дэвсгэртээ архидан согтуурахтай тэмцэх, архины хор уршгийг олон нийтэд таниулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг	Сумын Засаг даргын захирамжийн дагуу сар бүрийн 5, 15, 25-ний өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх талаар албан мэдэгдэл хүргүүлж Сайнгашуун, Сирина дэлгүүрийн ажиллах цагийн хуваарьт хяналт тавьж ажилласан.	100

		төрийн болон төрийн бус байгууллагыг дэмжиж, хамтран ажилласан байдал;	Мөн 21 насанд хүрээгүй, согтуу хүнд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх хүлээлгэх хариуцлагын талаар санамж, сэрэмжлүүлэг тараасан. Архидалтгүй аймаг Дундговь хөтөлбөрийн хүрээнд аймгийн АА бүлгээс ирж архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, архины зохистой хэрэглээ, гэр бүл, хамт олонд архидалтгүй орчинг бий болгоход чиглэгдсэн сургалтыг төрийн албан хаагчдад зохион байгуулсан. Мөн хөтөлбөрийн хүрээнд 10 сарын 7-нд Говь-угтаал суманд болсон сургалтанд байгууллагын дарга эрхлэгч нар хамрагдсан.	
	51	2.3.11 . согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагын үйлчилгээний цагийн хязгаарыг аймаг, сумын хэмжээнд шинэчлэн тогтоосон байдал;	Сумын Засаг даргын захирамжийн дагуу сар бүрийн 5, 15, 25-ны өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх талаар албан мэдэгдэл хүргүүлж Сайнгашуун, Сирина дэлгүүрийн ажиллах цагийн хуваарьт хяналт тавьж ажилласан.	100
ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ				93,3

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт гаргахад анхаарах асуудал

1. Ерөнхий сайдын 01 албан даалгавар, 258 тогтоол, 255 тогтоол, 32 тогтоол, хурлын тэмдэглэл зэрэг нь хоорондоо утга санаа, найруулгын хувьд ойролцоо, ижил төстэй, давхцал ихтэй байгаа тул заалтын утгыг сайтар уншиж өгсөн чиглэлийн дагуу биелэлтээ гаргана уу?
2. Хариуцлага тооцох тухай заалтын агуулгыг дотор нь :

№	Нэр	Хариуцлага тооцсон зөрчлийн төрөл /тоогоор /			Хариуцлага тооцсон байдал		
		Ёс зүйн зөрчил гаргасан ба согтуурсан	Хариуцлага алдсан	Өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй	Сахилгын шийтгэл авсан эсэх	Цалингийн хувь хассан эсэх	Ажлаас халсан эсэх
1	ЗДТГ	2	4	1	2	5	-
2	ЭМТ						
3	Сургууль						
4	Цэцэрлэг						
5	Соёлын төв						
	Бүгд						
	Нийт	7			7		

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

		Нийт	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөг чийн зарлиг	ЗГХЭГ- ын даргын тушаал	ЗГ-ын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		17	-	1	1	1	1	8	1	3	1
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		51	-	1	1	1	9	24	1	4	10
Бүрэн хэрэгжсэн	100%	42	-	1	1	-	7	19	1	4	9
Хэрэгжих шатанд	70%	8	-	-	-	1	2	4	-	-	1
Хэрэгжилт хангалтгүй	30%	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжээгүй	0%	1	-	-	-	-	-	1	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хугацаа болоогүй /	-	-	-	-	-	-	-	-	-	-
Биелэлтийн дундаж		93,3%		100	100	70	93,3	90,8	100	100	97

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР